



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2005 оны 11 сарын 16 өдөр

Дугаар 485

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгах тухай

Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 78 дугаар зүйл, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2005 оны 216 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. “Илгээмжийн худалдаа” нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгах ажлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. “Илгээмжийн худалдаа” нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын авлага, өр төлбөрийг байгууллага хүмүүстэй тооцоо нийлсэн дүнгээр барагдуулахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар /М.Цэрэндорж/-т зөвшөөрсүгэй.

Гурав. Татан буугдаж байгаа тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлах, хаалтын балансыг 2006 оны 1 дүгээр сарын 20-ны дотор гарган зохих байгууллагуудад ирүүлэхийг “Татан буулгах комисс” /Ж.Эрдэнэбаатар/-т даалгасугай.

Дөрөв. Байгууллагын баримт бичгийг архивлан Нийслэлийн Архивын алба /С.Гаваа/-д шилжүүлэхийг “Илгээмжийн худалдаа” нийслэлийн өмчит үйлдвэрийн газар /Ш.Баяраа/-т даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц.БАТБАЯР



Нийслэлийн Засаг даргын 2005 оны
11 сарын 16 өдрийн
435 дугаар захирамжийн хавсралт

**“ИЛГЭЭМЖИЙН ХУДАЛДАА” НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫГ ТАТАН БУУЛГАХ АЖЛЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН
БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга: Ж.Эрдэнэбаатар Нийслэлийн өмчийн харилцааны
газрын төлөөллийн хэлтсийн дарга

Комиссын нарийн бичгийн дарга: Ц. Оюунгэрэл Нийслэлийн өмчийн харилцааны
газрын мэргэжилтэн

Комиссын гишүүдэд:

Б.Батаа	Нийслэлийн өмчийн харилцааны газрын мэргэжилтэн
М.Энхболд	Нийслэлийн өмчийн харилцааны газрын мэргэжилтэн
Б.Саруул	Нийслэлийн өмчийн харилцааны газрын мэргэжилтэн
Я.Одгэрэл	Нийслэлийн өмчийн харилцааны газрын мэргэжилтэн